


Places to visit in  
the Great Gobi “B”  
Strictly Protected  
Area





# Places to visit in the Great Gobi "B" Strictly Protected Area



- ★ Soum center
- Camp points
- 🏠 Administration
- Track
- ▭ SPA border
- ▭ Soum border



MN



EN

0 12.5 25 50 75 100 Kilometers

# TAKHIIN TAL TOURIST CAMP



- Located in a Gobi nomadic lifestyle zone, the camp promotes wildlife observation and environmental education.
- Visitors have the opportunity to experience the lives of local herders, learn about their traditional livelihoods and nomadic homes, and even participate in their daily activities.
- The “Takhiin Tal” Tourist Camp serves as a unique eco-tourism center, offering insight into the Gobi’s natural environment, wildlife, nomadic culture, and livestock herding traditions.

# ТАХИЙН ТАЛ ЖУУЛЧНЫ БААЗ



- Баазын орчинд байрлах говийн нүүдэлчин амьдралын бүсэд, зэрлэг амьтдын ажиглалт, байгаль орчны боловсролыг дэмждэг.
- Жуулчид нутгийн малчдын амьдрал, уламжлалт нүүдлийн мал аж ахуй, амьдралтай танилцаж, тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох боломжтой.
- “Тахийн тал” жуулчны бааз нь Говийн байгаль, зэрлэг амьтан, нүүдэлчдийн соёл, мал аж ахуйг танин мэдэх эко аялалын өвөрмөц төв болж чаддаг.

# 1. BITUUT



- A scenic area with uniquely shaped rocks and stone formations.
- Observe the habitat of snow leopards and wild boars.
- Beyond the camping site, vehicles and motorcycles cannot proceed, so short-distance hiking is required.
- View the dunes and waterfall.

# 1. БИТҮҮТ



- Байгалын өвөрмөц тогтоцтой хад, чулуу бүхий үзэсгэлэнт газар
- Ирвэс болон зэрлэг гайхан амьдрах орчныг ажиглах
- Отоглох цэгээс цаашаа машин болон мотоцикл явах боломжгүй тул богино зайны явган аялал хийх
- Элсэн манхан болон хүрхрээ үзэх

## 2. YAGLAG



- Yaglag has a unique formation created by ancient glacial activity. Traces of glaciers, such as cirques and troughs, are commonly found here.
- Yaglag Gorge is a distinctive landscape of the Gobi, featuring wildlife and natural beauty.
- It is also possible to observe groups of wild sheep (Argali) and ibexes.

## 2. ЯГЛАГЫН ХАВЦАЛ



- Яглагийн хавцал нь эртний мөстлийн үйл ажиллагааны улмаас үүссэн өвөрмөц тогтоцтой. Энд хунх, тэвшин хөндий зэрэг мөстлийн ул мөрүүд элбэг тохиолддог.
- Яглагийн хавцал нь Говийн өвөрмөц тогтоц, зэрлэг амьтан, байгалийн үзэсгэлэнт газар юм.
- Аргаль, янгирын сүрэг ажиглах боломжтой.

### 3. ALAG KHAIRKHAN MOUNTAIN



- Alag Khairkhan Mountain offers an opportunity to explore the nomadic lifestyle, livestock husbandry, and natural beauty together.
- Mountain peaks, unique landforms, springs, and wildlife serve as subjects for nature photography and scientific research.

### 3. АЛАГ ХАЙРХАН УУЛ



- Алаг хайрхан уул нь БНГ буюу нүүдэлчдийн амьдрал, мал аж ахуй, байгалийн үзэсгэлэнг хамтад нь танин мэдэх боломжтой.
- Уулын оргил, байгалийн өвөрмөц тогтоц, булаг шанд, зэрлэг амьтан нь байгалийн зураг авах болон судалгааны үзмэр болдог.

## 4. TAMCHYN BELCHIR



- The Tamchyn Belchir is an area of great historical and cultural significance, rich in archaeological heritage. Stone monuments, deer stones, and burial mounds discovered here provide valuable insight into the life and culture of ancient nomadic peoples.
- The stone statue at Tamchyn Belchir is one of the monuments from the Turkic period, preserving information related to the social structure, customs, and burial rituals of that time. These monuments are of great importance for understanding the lifestyle and cultural characteristics of people from the ancient era.

## 4. ТАМЧИЙН БЭЛЧИР



- Тамчийн бэлчир нь эртний түүх соёлын дурсгалуудтай, археологийн хувьд чухал ач холбогдолтой газар юм. Эндээс хүн чулуун хөшөө, буган хөшөө, хиргисүүр зэрэг соёлын өвүүд илэрсэн нь тухайн үеийн нүүдэлчдийн амьдрал, соёлын талаар үнэт мэдээлэл өгдөг.
- Тамчийн бэлчирийн хүн чулуун хөшөө нь Түрэгийн үеийн дурсгалуудын нэг бөгөөд тухайн үеийн нийгмийн бүтэц, ёс заншил, оршуулгын зан үйл зэрэгт холбоотой мэдээллийг хадгалдаг. Эдгээр хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, соёлын онцлогийг судлахад чухал ач холбогдолтой.

# ADMINISTRATION



- The Administration of the Great Gobi “B” Strictly Protected Area is located in the southwestern part of Mongolia, on the southern slopes of the Altai Mountains, covering the southern territories of Bugat and Tonkhil soums of Govi-Altai aimag, and Altai, Uench, and Bulgan soums of Khovd aimag, with a total area of **1,835,724.94 hectares**.
- The Great Gobi “B” Strictly Protected Area is the second largest protected area in Mongolia and the eleventh largest in the world, preserving a unique and rare Gobi ecosystem.

# ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА



- Говийн Их Дархан Цаазат Газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаа нь Монгол орны баруун урд хэсэгт, Алтайн нурууны өвөрт, Говь-Алтай аймгийн Бугат, Тонхил, Ховд аймгийн Алтай, Үенч болон Булган сумдын урд хэсгийг хамарсан, нийтдээ **1,835,724.94 га** талбайтай тусгай хамгаалалттай газар юм.
- Говийн Их Дархан Цаазат Газрын “Б” хэсэг нь Монголд хоёрдугаарт, дэлхийд арван нэгдүгээрт ордог томоохон газар нутагтай бөгөөд дэлхийд ховор говийн экосистемийг хадгалсан онцгой бүс юм.

## 5. KHONIN US



- It is a green oasis of life and the source of water in the Gobi.
- Amid the arid region of the Gobi, it serves as a natural center of flowing water and lush pastures, where plant and animal life thrive.
- It is one of the few places in the world where two species of the horse family — the Przewalski's horse and the Asiatic wild ass — can be seen and observed together at the Khonin Us oasis.

## 5. ХОНИН УСНЫ БАЯНБҮРД



- Говийн усны ундарга, амьдралын ногоон арал.
- Говийн хуурай бүсийн дунд тогтмол ус урсгалтай, ургамал, амьтны амьдрал төвлөрсөн байгалийн ус, ногоон бэлчээрийн төв юм
- Дэлхийд адууны овгийн 2 зүйл болох Тахь болон Хуланг Хонин усны баянбүрдэд хамтад харах, ажиглах боломжтой

## 6. TAKHI US



- It is the source of water and life in the Gobi.
- It plays a crucial role in the Gobi ecosystem, serving as a habitat for many species of animals and plants, as well as a vital water source that helps prevent desertification.
- Visitors can also observe and photograph harems of wild Przewalski's horses up close.

## 6. ТАХЬ УСНЫ БАЯНБҮРД



- Говийн усны ундарга, амьдралын эх булаг юм.
- Говийн экосистемд онцгой үүрэгтэй бөгөөд амьтан, ургамлын олон төрөл зүйлийн амьдрах орчин, мөн цөлжилтөөс хамгаалах усны эх үүсвэр болдог.
- Зэрлэг тахийн сүргийг ойроос ажиглаж зураг авах боломжтой юм.

# 7. YOLKHON



- At Yolkhon oasis, many saxaul trees (tooroi) grow, and the local people regard these trees as sacred, considering the area to be a place of natural beauty, rest, and spiritual devotion.
- People visit the saxaul grove to relax, find peace of mind, and restore their spirit, and it is often described as a place of “breath of life” and “peace of the soul.”
- Around Yolkhon Lake, visitors can also observe water birds and migratory birds.

# 7. ЁЛХОНЫ БАЯНБҮРД



- Ёлхон баяны бүрдэд Тоорой мод олон ургасан, тэр моднуудыг нутгийнхан “хамгийн ариун, байгаль сайхан, амралт, сүсэглэлийн газар” гэж үздэг.
- Тоорой модны доор хүмүүс амрах, сэтгэл засах, тайвшрахыг хүссэнээр очдог, “амьсгалын дэлбээ”, “сэтгэлийн амар” гэсэн утгаар яригддаг.
- Ёлхон нуур орчимд усны болон нүүдлийн шувуудыг ажиглах боломжтой.

## 8. YMAAN US



- The Ymaan Us is located on the border of the local area, within a cliff inside the gorge.
- The rock carvings depict wild animals such as ibex, deer, and gazelle, as well as hunters with bows and arrows, and scenes of battle — including chariots, horsemen, and people riding in carts. Some of the carvings are believed to date back to the Xiongnu and Khanghan periods.
- On the cliff face, a Turkic inscription consisting of 29 characters, along with other intriguing markings, has been discovered — features that hold significant historical and archaeological value.

## 8. ЯМААН УС



- Ямаан усны хад нь нутгийн заагт, хавцал доторх өндөр цавчим ханан хаданд байрладаг.
- Хадны зургууд нь янгир, буга, зээр зэрэг ан амьтан, анчид (нум сумтай), мөн дайн тулааны үзэгдлүүд — тэрэг, морьтон, тэргэнд суусан хүн зэргийг дүрсэлсэн байдаг. Зарим зургуудыг Хүннү болон Хангин үеийнхтэй холбон үздэг.
- Ханан хад дээр 29 үсэг бүхий түрэг бичээс зэрэг сонирхолтой тэмдэглэгээ илэрсэн бөгөөд түүх, археологийн ач холбогдолтой.

# 9. СЭНЖИТ ХАД (БОДОНЧЫН ХАВЦАЛ)



## Сэнжит хадны домог

Эрт цагт Бодончийн хавцлын гүн дунд нэгэн буурал бадарчин аялж явжээ. Тэр бадарчин олон уул, усыг туулж, сэтгэлдээ тэнгэрийн жамыг эрэн бясалгал үйлддэг нэгэн байв. Нэг өдөр тэр хавцлын ёроолд ирж, “Энэ газар амгалан, салхи нь ариун, ус нь тунгалаг юм. Энд л би сэтгэлээ төвлөрүүлье” гэж хэлээд хадны хормойд суун бясалгал үйлджээ. Хоёр хоног, гурван шөнө, долоо хоног өнгөрөхөд тэр бадарчин хөдөлгөөнгүй суусаар, эцэст нь түүний бие гэгээрлийн гэрэлд уусан ариусч, дүр нь хаданд шингэжээ. Тэр үеэс эхлэн уг хадан цохио нарны туяанд гялбалзаж, хүн, амьтны дүр сүүдэр шиг сүүмэлздэг болсон гэдэг. Нутгийнхан үүнийг “Сэнжит хад” хэмээн нэрлэж, тэнд сүсэглэн мөргөж иржээ. Хэн нэгэн хүн сэтгэл зовлон, гунигт автаж энэ хаданд сүсэглэн залбирвал, түүний сэтгэл ариусч, зам нь цэлмэрдэг хэмээн өнөө хэр нутгийн ард итгэдэг байна.

## 9. SENJIT KHAD (BODONCH)



### Senjit Rock

Long ago, an old wandering monk traveled deep into the Bodonch. He had journeyed across many mountains and rivers, seeking the divine truth and meditating upon the ways of heaven. One day, as he reached the bottom of the gorge, he said, “This place is peaceful — the wind is pure, and the water is clear. Here, I shall calm my mind.” Then he sat beneath a rock and began to meditate. Days and nights passed — two days, three nights, then a week — yet the monk remained still. At last, his body was said to have merged with the light of enlightenment, and his figure became one with the rock itself. Since that time, the cliff has shimmered in sunlight, and shapes resembling people and animals seem to flicker upon it. The local people began to call it “**Senjit Khad**” and have worshiped it ever since. It is believed that if a person burdened with sorrow or worry prays sincerely at this rock, their heart will be cleansed and their path will become clear.